

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 07 дугаар сарын мэдээлэл

2024.074.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Монгол УлсынТөрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоол, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сумын Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар “ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”-г 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй томилж, үүрэг чиглэл өгсөн.

-Ардын Хувьсгалын 103 жилийн ойн баяр наадмыг ёслол төгөлдөр тэмдэглэх тухай сумын Засаг даргын 2024 оны А/52, 53 дугаар захирамжаар ажлын хэсэг томилж, ОНХС-ийн батлагдсан эх үүсвэрээс 10 сая төгрөгийг баяр наадмын үйл ажиллагаанд зарцууллаа. 103 жилийн ойн баяр наадмаар

а/. Сумын заан цолтой бөх

б/. Сумын мэргэн харваач

в/. Сумын гарамгай харваач тус тус тодорлоо.



- Сумын Засаг даргын 2024 оны А/57 дугаар захирамжаар 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 8 нэгж талбарыг малчдын хоршоонд эзэмшүүлэхээр төсөл сонгон шалгаруулалтаар шийдвэрлэхээр нийтэд зарлав.

-Сумын Засаг даргын 2024 оны А/16 дугаар захирамжаар “Тамгын газрын дотоод хяналтын журам”-ыг шинэчлэн батлав.

- БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОВСРУУЛАХ ажлын хүрээнд Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөө аж ахуй, Байгаль орчны бодлогоор "БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР

ҮЗҮҮЛЭЛТ"-ийг 3 төрлөөр 16 чиглэлээр гаргасан. 2. Сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг ерөнхий 7 ангилалын дагуу 9 дэд ангилалаар тооцон гаргаж, аймгийн ХШҮ-ний хэлтэст хүргүүллээ.

Сургалт сурталчилгааны чиглэлээр

-2024.07.07 ны өдөр “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хор хохирлын тухай иргэд манлайлсан судалгаа” төслийн талаар “Нийтийн сонсгол” -ыг 42 хүнийг оролцуулан зохион байгуулж, судалгааны дүгнэлтээр хэлэлцүүлэг зохион байгуулж, тайлан, илтгэлийг бичиж УБ хот “Хүний эрх хөгжил төв” ТББ-д цахимаар илгээлээ.



2024.04.19 нд батлагдсан “УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙД ТУЛГАМДАЖ БАЙГАА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ШАЛТГААЛСАН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ” хууль 2024.04.24 нөөс мөрдөгдсөнтэй холбогдуулан дээрх судалгааны дүнг хэлэлцэж, мөн уг хуулийг сурталчлан ажиллаж байна

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

-Сумын Засаг даргын 2024 оны А/50 дугаар захирамжаар малын мялзан өвчинтэй холбоотойгоор хорио цээрийн дэглэмийг 4 дүгээр багийн “Баянголын салаа” хэмээх газарт орших малын 2 өрхийн хотонд зохион байгуулж, бүхий л талын арга хэмжээг авч ажилласны үр дүнд өвчлөлийг намжаасан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

ЭМГазар, АНЭ-ийн төрөх тасгаас жирэмсэн эхчүүдэд зориулагдсан цахим сургалт 2 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Энэ өдрийн сургалт "Жирэмсэн үеийн таргалалт, хоол эмчилгээ", "Жирэмсний хяналт, хяналтад эрт орохын ач холбогдол" сэдвийн хүрээнд аймгийн хэмжээнд 50 гаруй жирэмсэн эх хамрагдсан байна. Эрүүл мэндийн төвийн зүгээс сургалтыг 13 жирэмсэн эхэд хүргэсэн боловч 5 жирэмсэн эх хамрагдлаа.

Улсын баяр наадмын амралтын үед Эрүүл мэндийн газраас гаргасан зөвлөмжүүдийг тухай бүр нь “Эрүүл мэндийн төв Дарьганга” фэйсбүүк хаягт

байршуулан ард иргэдэд цахимаар мэдээлэл хүргэн ажиллаж байна. Жишээ нь: /баяр наадмын өдрүүдэд гол усны аюулаас сэргийлэх зөвлөмж, наршилтаас сэргийлэх зөвлөмж, гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөмж гэх мэт/



2024.07.04,05-нд аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч н.Алтанцэцэг Эрүүл мэндийн төв болон 2 эмийн санд эм, биобэлдмэлийн чиглэлээр хяналтын хуудсаар хяналт шалгалт хийж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Соёлын чиглэлээр:

Монгол Улсын Соёлын сайдын 2024.05.15 ны өдрийн А/255 дугаар тушаалаар Монгол улсын нутаг дэвсгэрт археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлаг судалгаа хийхийг зөвшөөрсний дагуу аймгийн СУГазар, Монгол Улсын боловсролын Их Сургуулийн нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгааны ангитай хамтран бүс нутагт неолитын судалгааны ажлыг эхлүүлээд ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр:

2024.07.02- ноос эхлэн бүх нийтийн цэвэрлэгээг эхлүүлж, нийтийн эзэмшлийн нэгдсэн хогийн цэгт цэвэрлэгээ хийлээ.



2024.07.15 нд түр зуурын усархаг борооны улмаас тус сумын 2 дугаар багийн малчин өрх толгойлсон эмэгтэй гэр усанд хөвж, мөн 1 дүгээр багийн малчны 100 гаруй ямаа усанд живсэн зэрэг хохиролд сумын Онцгой комисс аврах арга хэмжээг авсан.



ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР